




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона
вируст (Covid-19) халдварын тархалтаас
урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга
хэмжээний үзүүлсэн нөлөөлөл
3 дахь шатны тандалт судалгаа

ОРШИЛ

Дэлхий нийтээр тархсан Корона вирус (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг арга хэмжээг Монгол улсад бүртгэгдсэн анхны тохиолдлоос эхлэн Засгийн газраас зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 11-р сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж, түүнээс хойш 11-р сарын 15-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаж, 11-р сарын 29-ний өдрийн 194 дүгээр тогтоолоор “Бэлэн байдлын зэрэг”-ийг бууруулах, хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх, 12-р сарын 9-ний өдрийн 209 дүгээр тогтоолоор “Бэлэн байдлын зэрэг”-ийг бууруулах, хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах, 12-р сарын 21-ний өдрийн 226 дугаар тогтоолоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлэх, 2021 оны 1-р сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг 2021 оны 1-р сарын сарын 11-ний өдрийг хүртэл сунгах шийдвэрүүдийг гаргаад байна.

Энэхүү цар тахал нь дэлхийн 200 гаруй улс оронд тархаж, эдийн засгийн хямралыг бий болгоод байна. Түүнчлэн хямралын үед эдийн засгийн өсөлтөд эсрэг нөлөө үзүүлж эхэлсэн байна. Манай улсын хувьд эдийн өсөлт 2020 оны 3-р улирлын байдлаар 7.3 хувиар буурсан дүнтэй байна. ДНБ 7.3 хувиар буурахад уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 595.5 (20.7%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 401.4 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Шинэ төрлийн коронавируст халдварын тархалт, цар тахлаас үүдсэн эрэлт, нийлүүлэлтийн тэнцэр алдагдаж, тухайлбал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, импортын нийлүүлэлтийн хэмжээ болон хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспортын хэмжээ зэрэг эрэлтийн үзүүлэлтүүд буурч байна. Үйлдвэрлэл, тээвэр, аялал жуулчлал, зочид буудал, зоогийн газар, худалдаа, үйлчилгээний салбаруудын үйлчлүүлэгдийн тоо, орлого буурах, дампуурах, ажлын байраа алдах зэргээр бизнесийн цар хүрээ, хэмжээнээс үл хамаарсан сорилт, бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй болж байна.

Иймд ҮСХ-оос 2020 оны 5 дугаар сарын 6-14-ний өдрүүдэд “ААНБ-ын үйл ажиллагаанд Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл”-ийн эхний шатны тандалт судалгааг 21 аймаг, 7 дүүргийн 2402 ААНБ-аас нээлттэй онлайн хэлбэрээр, цуглуулан авч, боловсруулан үр дүнг 6 дугаар сард тархаасан.

Хоёр дахь шатны (онлайн) панел судалгаанд эхний шатанд хамрагдсан 2402 ААНБ-ын үйл ажиллагааг тандах зорилгоор мэдээлэл цуглуулалтыг 2020 оны 7 дугаар сарын 27-ноос 8-р сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан.

2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс Монгол Улс анх удаа “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжиж, Корона вирус халдвар голомтлон гарсан зарим аймаг, сумдад “Тэг зогсолт” хийсэн зэрэг гамшгийн онцгой нөхцөл байдал нь ААНБ-ын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлснийг судлах зорилгоор ҮСХ-ноос 3 дахь шатны панел судалгааг 2020 оны 12-р сарын 15-наас 2021 оны 1-р сарын 4-ний өдрүүдэд зохион байгуулж зохион байгуулж, үр дүнг тайлагнаж байна.

Энэ удаагийн судалгаанд “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжсэнээс шалтгаалан ААН-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх, тэдний орлого, үйлдвэрлэлд ямар өөрчлөлт гарч байгаа болон ажлын байраа хадгалж буй байдал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос тухай бүр гаргаж байгаа шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрхэн удирдаж, төлөвлөж байгаа талаар судлахыг зорьсон болно. Мөн төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарын ААН-үүдийг оруулаагүй болно.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2020 оны жилийн эцсийн байдлаар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	94 491	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	37 784	40.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9 021	9.5
Барилга	7 651	8.1
Боловсруулах үйлдвэрлэл	6 355	6.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5 382	5.7
Боловсрол	4 580	4.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3 441	3.6
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3 250	3.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2 758	2.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2 361	2.5
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2 314	2.4
Мэдээлэл, холбоо	2 014	2.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 797	1.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 596	1.7
Уул уурхай, олборлолт	1 287	1.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1 240	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1 165	1.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	264	0.3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	195	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	36	0.0

“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл” 3 дахь шатны тандалт судалгаанд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 2388 аж ахуйн нэгж хамрагдсан.

ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ,
3 судалгааны дүнгээр



Корона вирус (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь судалгаанд хамрагдсан 2388 аж ахуйн нэгжийн 826 (34.6%) нь үйл ажиллагаа хэвийн явагдаж байна, 1562 (65.4%) нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ.

2020 оны 5-р сард явуулсан эхний шатны тандалт судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 46.3 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан бол 7-р сард явагдсан 2 дахь шатны судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 52.2 хувь нь үйл ажиллагаа нь хэвийн буюу өмнөх судалгааны үр дүнгээс 5.9 пунктээр

нэмэгдсэн бол 3 дахь шатны тандалт судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 34.9 хувь нь үйл ажиллагаа хэвийн явагдаж байна гэж хариулжээ. Энэ нь жилийн дунд хэсгээр буюу 3 дугаар улиралд ААН-үүдийн үйл ажиллагаа нь эхний улиралтай харьцуулахад сэргэж ирсэн бөгөөд 2020 оны 11-р сарын 11-нээс хойш “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа ААН-ийн эзлэх хувь 2 дахь шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад 17.3 пунктээр нэмэгдсэн байна.

Корона вирусний халдварын үед болон урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь судалгаанд хамрагдсан 2388 аж ахуйн нэгжийн 826 (34.6%) нь үйл ажиллагаа хэвийн явагдаж байна, 1562 (65.4%) нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 826 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар (Хүснэгт 2) харуулбал:

- 257 (31.1%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 79 (9.6%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 74 (9.0%) нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа,
- 71 (8.6%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа,
- 70 (8.5%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар,
- 287 (33.3%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, барилга, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, боловсрол, тээвэр агуулах, санхүүгийн болон даатгал, мэдээлэл холбоо, цахилгаан, хий, агааржуулалт, үүл уурхай, олборлолт, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, ус хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх, аялал жуулчлал, урлаг, үзвэр, тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.


ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 3 шатны судалгаанд хамрагдсан ААН-ийн тоогоор

Салбар	Бүгд	Хэвийн			Хэвийн бүс		
		Эхний судалгаа	2 дахь шатны	3 дахь шатны	Эхний судалгаа	2 дахь шатны	3 дахь шатны
Бүгд	2 402	1 113	1 255	826	1 289	1 147	1 562
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	161	96	97	70	65	64	91
Уул уурхай, олборлолт	31	16	16	11	15	15	20
Боловсруулах үйлдвэрлэл	218	112	99	79	106	119	139
Цахилгаан, хий, агааржуулалт	15	8	10	13	7	5	2
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	9	7	7	8	2	2	1
Барилга	198	93	117	34	105	81	164
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	557	289	350	257	268	207	300
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	116	47	45	30	69	71	86
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	219	63	103	45	156	116	174
Мэдээлэл, холбоо	29	11	16	15	18	13	14
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	82	53	49	24	29	33	58
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	77	38	33	12	39	44	65
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	72	35	35	33	37	37	39
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	32	15	20	10	17	12	22
Аялал жуулчлал	72	6	5	7	66	67	65
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	14	12	11	-	2	3	-
Боловсрол	205	48	90	31	157	115	174
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	115	76	80	74	39	35	41
Урлаг, үзвэр, тоглоом	39	9	16	2	30	23	37
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	141	79	56	71	62	85	70

Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 557 ААН-ийн 53.9 хувь нь “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна” гэж хариулжээ. Түүнчлэн:

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын үйл ажиллагаа 161 ААН-ийн 56.5 хувь,
- Боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 218 ААН-ийн 63.8 хувь,
- Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг 219 ААН-ийн 79.5 хувь,
- Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг 198 ААН-ийн 82.8 хувь,
- Боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг 205 ААН-ийн 84.9 хувь нь үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.

ЗУРАГ 2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАХГҮЙ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, салбараар



Судалгаанд “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байгаа” гэсэн хариулт өгсөн 1562 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулбал:

- 300 (19.2%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 174 (11.1%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 174 (11.1%) нь боловсролын салбар,
- 164 (10.5%) нь барилгын салбар,
- 139 (8.9%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 91 (5.8%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар,
- 520 (33.3%) нь тээвэр, агуулах, үйлчилгээний бусад, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн болон даатгал, хүний эрүүл мэнд, нийгмийн халамж, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, урлаг, үзвэр, тоглоом, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, цахилгаан, хий, агааржуулалт, ус хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн шийдвэртэй холбогдуулан “Үйл ажиллагаа нь хэвийн бус” гэж хариулсан 1562 ААН-ийн 1372 (87.8%) нь үйл ажиллагаа нь хүндэрсэн гэж хариулжээ. Харин 190 (12.1%) нь дээрх шийдвэрээс шалтгаалж үйл ажиллагаанд хүндрэл учраагүй гэсэн хариултыг өгсөн байна.

ХҮСНЭГТ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар

№	Эхний шатны тандалт судалгаа		2 дахь шатны тандалт судалгаа		3 дахь шатны тандалт судалгаа	
	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь
1	Санхүүгийн байдал хүндэрсэн	48.2	Санхүүгийн байдал хүндэрсэн	43.8	Санхүүгийн байдал хүндэрсэн	55.5
2	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	44.9	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	37.2	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг дуустал үйл ажиллагаагаа түр зогсоосон	47.2
3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	27.8	Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөл хорио тавигдтал үйл ажиллагаагаа түр зогсоосон	36.3	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	41.4
4	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	24.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	22.8	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	31.7
5	Зээл, зээлийн хүүг төлөхөд хүндрэлтэй болсон	23.8	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	20	Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	27.2

Үйл ажиллагаа нь хүндэрсэн гэж хариулсан ААН-ийн дийлэнх нь буюу 43.8%-55.5% нь “Санхүүгийн байдал хүндэрсэн” гэсэн хариултыг өгсөн байна. 3 дахь шатны судалгааны хувьд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацаа дуустал үйл ажиллагаагаа түр зогсоосон ААН үйл ажиллагаа нь хэвийн бус ААН-ийн дүнд 47.2 хувийг эзэлж байна. Мөн ААН-үүдийн хувьд 3 шатны судалгаанд үйлчлүүлэгчийн тоо буурсан, ажиллагчдын цалин, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон, зээл, зээлийн хүүг төлөхөд хүндрэлтэй болсон зэрэг шалтгаануудыг хамгийн ихээр дурдсан байна.

ХҮСНЭГТ 4. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, шалтгаанаар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	ААН-ийн дүнд эзлэх хувь
Санхүүгийн байдал хүндэрсэн	762	55.5
Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг дуустал үйл ажиллагаагаа түр зогсоосон	648	47.2
Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	568	41.4
Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	435	31.7
Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	373	27.2
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	359	26.2
Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	334	24.3
Түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон	267	19.5
Түүхий эд, материал, барааны татан авалт зогссон	258	18.8
Бусад төлбөр төлөхөд хүндрэлтэй болсон (ус, цахилгаан, дулаан гэх мэт)	225	16.4
Төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийгдээгүй, хойшилсон	196	14.3
Түүхий эд, бараа, үйлчилгээний эрэлт эрс буурсан	189	13.8
Түүхий эд, материал, барааны нөөц багассан	175	12.8
Түүхий эд, материал, барааны татан авалт удааширсан	166	12.1
Бусад	143	10.4
Ажиллагчдын тоог бууруулсан	140	10.2
Түүхий эд, материал, барааны хомсдол үүсэж, дууссан	138	10.1
Түүхий эд, материал, бараа, үйлчилгээг цаг хугацаанд нь хүргэж чадахгүй болсон	138	10.1

Тайлбар: Хариулт нь олон сонголттой бөгөөд олон давтагдсанаар нь эрэмбэлсэн.

2. ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан гэж хариулсан 1372 ААН-ийн дийлэнх нь буюу 1295 (94.4%) нь Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан “Орлого буурсан” гэж хариулсан бол 77 (5.6%) нь орлого буураагүй гэсэн хариулт өгчээ.

“Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалж, орлогод үзүүлсэн нөлөөг өмнөх сар болон өмнөх улиралтай харьцуулан асууж, үр дүнг гаргалаа.

ЗУРАГ 3. ОРЛОГО БУУРСАН ААН-ИЙН ЭЗЛЭХ ХУВИЙГ ӨМНӨХ ШАТНЫ СУДАЛГААНУУДЫН ҮР ДҮНТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, орлогын бүлгээр



2020 оны 5-р сард явагдсан эхний шатны судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 43.7 хувийнх нь орлого 50-иас дээш хувиар буурсан байна. 3 дахь шатны судалгааны үр дүнг 2 дахь шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад, 50-иас дээш хувиар орлого нь буурсан ААН 2.1 пунктээр, 10 хүртэл хувиар

буурсан ААН-ийнх 0.6 пунктээр, 31-40 хувиар буурсан ААН-ийнх 0.1 пунктээр тус тус өссөн бол 41-50 хувиар буурсан ААН-ийнх 0.6 пунктээр, 11-20 хувиар буурсан ААН-ийнх 1.0 пунктээр, 21-30 хувиар буурсан ААН-ийнх 1.0 пунктээр тус тус буурсан байна.

Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан орлого буурсан гэж хариулсан 1295 аж ахуйн нэгжийг салбараар харуулбал,


- 245 (18.9%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ
- 159 (12.3%) нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 141 (10.9%) нь боловсролын салбар,
- 126 (9.7%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 118 (9.1%) нь барилгын салбар,
- Үлдсэн 506 (39.1%) хувь нь бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байна.

Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох шийдвэрээс шалтгаалан орлого нь өмнөх сараас буурсан ААН-үүдийг 2 дахь шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад,

- Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ эрхэлдэг ААН 1.5 пунктээр,
- Барилгын салбарын ААН 2.6 пунктээр, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ААН 1.6 пунктээр,
- Боловсролын салбарын ААН 1.1 пунктээр, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын ААН 0.6 пунктээр тус тус өссөн байгаа бөгөөд орлого хамгийн ихээр буурсан байдал хэвээр хадгалагдаж байна.
- Харин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ААН 1.3 пунктээр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа эрхэлдэг ААН 2.6 пунктээр, тээвэр, агуулахын үйл ажиллагаа явуулдаг ААН 1.7 пунктээр тус тус буурсан байна.

2.A. ОРЛОГЫГ ӨМНӨХ САРТАЙ ХАРЬЦУУЛСНААР


ЗУРАГ 4. ОРЛОГО НЬ ӨМНӨХ САРААС БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖ, салбараар



ХҮСНЭГТ 5. ОРЛОГО БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, дүнд эзлэх хувиар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	1295	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	245	18.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	159	12.3
Боловсрол	141	10.9
Боловсруулах үйлдвэрлэл	126	9.7
Барилга	118	9.1
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	67	5.2
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	67	5.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	58	4.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	56	4.3
Аялал жуулчлал	55	4.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	53	4.1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	35	2.7
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	33	2.5
Урлаг, үзвэр, тоглоом	33	2.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	18	1.4
Уул уурхай, олборлолт	15	1.2
Мэдээлэл, холбоо	14	1.1
Цахилгаан, хий, агааржуулалт	1	0.1
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1	0.1


ЗУРАГ 5. ОРЛОГО НЬ ӨМНӨХ САРААС БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖ, орлогын бүлгээр, дүнд эзлэх хувиар



Өмнөх сараас орлого буурсан гэж хариулсан 1295 аж ахуйн нэгжээс орлогын бууралтыг хувиар тодруулахад, 858 (66.2%) нь орлого нь 50-иас дээш хувь, 162 (12.4%) нь 41-50 хүртэл хувь, 132 (10.2%) нь 31-40 хүртэл хувь, 87 (6.7%) нь 21-30 хүртэл хувь, 35 (2.7%) нь 11-20 хүртэл хувь, 23 (1.8%) нь 10 хүртэл хувиар орлого буурсан гэсэн хариулт өгсөн байна.

2.Б. ОРЛОГЫГ ӨМНӨХ УЛИРАЛТАЙ ХАРЬЦУУЛСНААР

ЗУРАГ 6. ОРЛОГО НЬ ӨМНӨХ УЛИРЛААС БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖ, орлогын бүлгээр, дүнд эзлэх хувиар



Өмнөх улирлаас орлого буурсан гэж хариулсан 1295 аж ахуйн нэгжээс орлогын бууралтыг хувиар тодруулахад, 840 нь орлого нь 50-иас дээш хувь, 183 нь 41-50 хүртэл хувь, 118 нь 31-40 хүртэл хувь, 80 нь 21-30 хүртэл хувь, 52 нь 11-20 хүртэл хувь, 22 нь 10 хүртэл хувиар орлого буурсан гэсэн хариулт өгсөн байна.


Өмнөх улирлаас буурсан орлогын бууралтыг өмнөх сартай харьцуулахад 50-иас дээш хувиар буурсан ААН-ийнх 1.3 пунктээр, 31-40 хувиар буурсан ААН-ийнх 1.1 пунктээр, 21-30 хувиар буурсан ААН-ийнх 0.5 пунктээр, 10 хувь хүртэл буурсан ААН-ийнх 0.1 пунктээр тус тус буурсан бол 41-50 хувиар буурсан ААН-ийнх 1.8 пунктээр, 11-20 хувиар буурсан ААН-ийнх 1.3 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн сард орлого буурах байдал өмнөх улиралтай харьцуулахад эрчтэй явагдсаныг харуулж байна.

3. ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотой үйлдвэрлэлд үзүүлсэн нөлөөг өмнөх сар, улиралтай харьцуулан асууж, үр дүнг гаргасан.

3.А.ӨМНӨХ САРТАЙ ХАРЬЦУУЛСНААР

ЗУРАГ 7. ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖ, бүлгээр, өмнөх сартай харьцуулснаар, дүнд эзлэх хувь




Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа 1295 ААН-ийн дийлэнх буюу 1119 (86.4%) нь Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбогдуулан үйлдвэрлэл буурсан гэж хариулсан бол 176 (13.6%) нь энэ шийдвэрээс хамааран үйлдвэрлэл буураагүй гэж хариулсан байна.

Үйлдвэрлэл нь өмнөх сараас буурсан нийт ААН-ийн дийлэнх буюу 62.4 хувь нь үйлдвэрлэл нь 50-иас дээш хувиар, 13.7 хувь нь 41-50 хувиар, 10.1 хувь нь 31-40 хувиар, 8.7 хувь нь 21-30 хувиар, 2.9 хувь нь 11-20 хувиар, 2.1 хувь нь 10 хүртэл хувиар үйлдвэрлэл буурсан гэж тус тус хариулсан байна.

3.Б.ӨМНӨХ УЛИРАЛТАЙ ХАРЬЦУУЛСНААР

ЗУРАГ 8. ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖ, бүлгээр, өмнөх улиралтай харьцуулснаар, дүнд эзлэх хувь



Харин Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан үйлдвэрлэл нь өмнөх улиралтай харьцуулахад буурсан ААН-ийн дийлэнх буюу 708 (63.2%) нь 50-иас дээш хувиар, 165 (14.7%) нь 41-50 хувь, 106 (9.5%) нь 31-40 хувь, 89 (7.9%) нь 21-30 хувь, 31 (2.8%) нь 11-20 хувь, 20 (1.8%) нь 10 хүртэл хувиар үйлдвэрлэл буурсан гэж хариулсан байна.

Өмнөх улиралтай харьцуулахад 40-өөс дээш хувиар үйлдвэрлэл нь буурсан ААН-үүдийн эзлэх хувь нь өмнөх сартай харьцуулахад 0.8-1.0 пунктээр нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас гаргасан шийдвэртэй уялдан улирлын туршид үйлдвэрлэл буурсаар байгаа байдал ажиглагдаж байна.

4. АЖИЛЛАГЧДАДАА ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ЗАЙНААС АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

ХҮСНЭГТ 6. ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ЗАЙНААС АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

	Эхний шатны судалгаа		2 дахь шатны судалгаа		3 дахь шатны судалгаа	
	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	2402	100.0	2402	100.0	2388	100.0
Цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлсэн	814	33.9	896	37.3	989	41.4
Цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлээгүй	1588	66.1	1506	62.7	1399	58.6

Засгийн газраас анх удаа 2020 оны 11-р сарын 11-нд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс хойших хугацаанд судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 989 (41.4%) нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн бол 1399 (58.6%) нь буюу дийлэнх нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлээгүй гэж хариулсан байна.

Энэ нь эхний шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ААН-ийн эзлэх хувь 7.5 пунктээр, 2 дахь шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад 4.1 пунктээр өссөн байна.

Ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн 989 ААН-ээс энэ арга хэмжээгээ одоо үргэлжлүүлж буй эсэхийг асуухад 767 (77.6%) нь тийм, 222 (22.4%) нь үгүй гэж хариулсан байна. Энэ нь 2 дахь шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад дээрх арга хэмжээг үргэлжүүлэн авч хэрэгжүүлж байгаа ААН-ийн эзлэх хувь 13.5 пунктээр нэмэгдсэн байна.


ХҮСНЭГТ 7. ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ГЭРЭЭСЭЭ АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ БАЙГАА БАЙДАЛ

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	989	100.0
Гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байгаа	767	77.6
Гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ч үргэлжлүүлэн хэрэгжүүлээгүй	222	22.4

Корона вирусний тархалт дэлхий нийтээр эрчимтэй явагдаж, эхний давлагаа хүчтэй өрнөж байх үед судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 37.3 хувь нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлж байсан бол одоо 31.9 хувь нь тус арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна. Энэ хувь нь эхний давлагааны үеийнхээс 5.4 пунктээр буурсан байна.

5. ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРЭЭС ШАЛТГААЛАН ААНБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ


ЗУРАГ 9. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ



Судалгаанд хамрагдсан 2388 ААН-ийн дийлэнх буюу 1152 (48.2%) нь Засгийн газраас гаргасан шийдвэртэй уялдуулан “Тэг зогсолт” хийж, үйл ажиллагаагаа зогсоосон бол, 816 (34.2%) нь хэсэгчлэн үйл ажиллагаа явуулсан, 420 (17.6%) нь үйл ажиллагаагаа хэвийн явуулсан гэсэн хариултыг өгсөн байна. Хэвийн ажилласан ААН-үүд нь “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацаанд хэвийн ажиллах салбаруудын жагсаалтад багтсан ААН-үүд байна.

6. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ

ЗУРАГ 10. ААН-ИЙН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР



Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх буюу 1682 (70.4%) нь 1-9 ажиллагчидтай, 371 (15.5%) нь 10-19 ажиллагчидтай, 195 (8.2%) нь 20-29 ажиллагчидтай, 140 (5.9%) нь 30-39 ажиллагчидтай ААН-үүд байна.

Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 244 (10.2%) нь Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын

зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа нь хүндэрч, ажиллагчдаа цомхотгох арга хэмжээ авсан бол дийлэнх нь 2144 (89.8%) цомхотгол хийгээгүй байна.

ЗУРАГ 11. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОСОН ААН



Үүнээс харахад судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь буюу 89.8 хувь (2144) нь ажиллагчдаа цаашид цомхотгохгүйгээр ажиллуулах хүсэл эрмэлзэлтэй байгаа байдал ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 8. ЦОМХОТГОЛ ХИЙСЭН ААН,
цомхотгосон ажиллагчдын тооны бүлгээр

Ажиллагчдаа цомхотгосон 244 ААН-ийг цомхотгосон ажиллагчдын тооны бүлгээр задалж авч үзвэл, дийлэнх буюу 1-9 хүртэл ажиллагчдаа цомхотгосон 213 ААН буюу 87.3 хувь, 10-19 хүртэл ажиллагчдаа цомхотгосон 28 ААН буюу 11.5 хувь, 20-29 ажиллагчдаа цомхотгосон 1 ААН буюу 0.4 хувь, 30-39 ажиллагчдаа цомхотгосон 2 ААН буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна.

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	244	100.0
1-9 ажиллагч	213	87.3
10-19 ажиллагч	28	11.5
20-29 ажиллагч	1	0.4
30-39 ажиллагч	2	0.8

ХҮСНЭГТ 9. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОХГҮЙ БАЙХ
БОЛОМЖТОЙ ХУГАЦАА, бүлгээр


	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	2388	100.0
3 хүртэлх сар	340	14.2
3 – 6 сар	158	6.6
6 – 12 сар	79	3.3
Цомхотгол хийхгүй	908	37.8
Тодорхойгүй	903	37.6

Цаашид ямар хугацаанд ажиллагчдаа цомхотгохгүй байх боломжтой эсэхийг тодруулан асуухад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 908 (37.8%) нь цомхотгол хийхгүй гэж хариулсан бол 903 (37.6%) нь тодорхойгүй, 340 (14.2%) нь 3 хүртэл сарын хугацаанд цомхотгол хийхгүй, 158 (6.6%) нь 3-6 сар хүртэлх хугацаагаар цомхотгол

хийхгүй, хамгийн бага буюу 79 (3.3%) нь 6-12 сар хүртэлх хугацаагаар цомхотгол хийхгүй байх боломжтой гэж хариулсан байна.

7. ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ШИЙДВЭРТ ХАМРАГДСАН БАЙДАЛ

ЗУРАГ 12. ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ШИЙДВЭРТ ХАМРАГДСАН БАЙДАЛ



- Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдсан
- Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдаагүй

Судалгаанд хамрагдсан 2402 ААН-ийн 1595 (66.8%) нь Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим салбарын ААНБ-ын цахилгаан, дулаан, хогны зардлыг 2020 оны 12-р сарын 1-нээс 2021 оны 7-р сарын 1 хүртэлх хугацаанд төр хариуцах шийдвэрт хамрагдсан бол 793 (33.2%) нь уг шийдвэрт хамрагдаагүй байна.

ХҮСНЭГТ 10. ЦААШИД ЗАСГИЙН ГАЗРААС “БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГ”-Т ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ ҮРГЭЛЖЛҮҮЛБЭЛ ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ


Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг үргэлжлүүлж, сунгавал ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар тодруулахад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх буюу 1346 (56.4%) нь маш их сөрөг нөлөөтэй, 671 (28.1%) нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй, 248 (10.4%) нь бага зэрэг сөрөг нөлөөтэй, 123 (5.2%) нь ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж хариулсан байна.

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	2388	100.0
Маш их сөрөг нөлөөтэй	1346	56.4
Дунд зэрэг сөрөг нөлөөтэй	671	28.1
Бага зэрэг сөрөг нөлөөтэй	248	10.4
Ямар нэг нөлөө үзүүлэхгүй	123	5.2

8. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА

Судалгаанд хамрагдсан 2388 ААН-ээс Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ тавигдсанаас хойш үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацааны талаар тодруулсан.

ЗУРАГ 13 . ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА, ААН-ийн тоогоор, 3 шатны судалгааны дүнгээр



Нийт ААН-ийн 774 (32.2%) нь 3 сар хүртэл, 494 (20.6%) нь 3-6 сар хүртэл, 224 (9.3%) нь 6-12 сар хүртэл, 106 (4.4%) нь 1 жилээс дээш хугацаа шаардагдана гэж хариулсан байна. Харин хамгийн их буюу 790 (32.9%) нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхлэх хугацаа тодорхойгүй гэсэн хариултыг өгсөн байна.

9. ААН-ЭЭС ӨГСӨН ЗАСГИЙН ГАЗРААС ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн хувьд төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- Зээл авах боломжийг бий болгох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх – 950
- Үйл ажиллагаагаа сэргээхэд гарах асуудлуудыг төрийн бодлогоор шуурхай шийдэхэд дэмжлэг үзүүлэх - 981
- Эрсдэл, гамшгийн үед ААН-ийн үйл ажиллагаа эдийн засагт учирч болох болзошгүй аюулаас сэргийлэх, даван туулах стратеги, бодлогыг боловсруулах – 1207
- Бусад – 211

Бусад шалтгаантай ААН-үүдийн саналыг олон давтагдсан байдлаар нь эрэмбэлж авч үзвэл, зээлийн хүүг тэглэх, бага хүүтэй, хөнгөлөлттэй зээл олгох, НӨАТ, НДШ, ААНОАТ-ыг тэглэх, татварын хөнгөлөлт үзүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, мөн нийслэл Улаанбаатар хотод хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор QR кодыг ААНБ-уудад чөлөөтэй олгох, түгээлтийн асуудлыг шийдвэрлэх, хөл хорионы үеэр оновчтой, зөв төлөвлөлт хийж, халдварын голомтыг хязгаарлах гэсэн хариултууд байна.

ДУГНЭЛТ

Засгийн газраас “Бүх нийтийн болон Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн нь ААН-ийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсээр байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал, 3 дахь шатны панел судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 1562 (65.4%) нь үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна гэж хариулсан байна. Энэ нь эхний шатны судалгааны үр дүнгээс 11.7 пунктээр, 2 дахь шатны судалгааны үр дүнгээс 17.6 пунктээр нэмэгдсэн байна.

2020 оны 5-р сард явагдсан эхний шатны судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 43.7 хувийнх нь орлого 50-иас дээш хувиар буурсан байна. 3 дахь шатны судалгааны үр дүнг 2 дахь шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад, 50-иас дээш хувиар орлого нь буурсан ААН 2.1 пунктээр, 10 хүртэл хувиар буурсан ААН-ийнх 0.6 пунктээр, 31-40 хувиар буурсан ААН-ийнх 0.1 пунктээр тус тус өссөн бол 41-50 хувиар буурсан ААН-ийнх 0.6 пунктээр, 11-20 хувиар буурсан ААН-ийнх 1.0 пунктээр, 21-30 хувиар буурсан ААН-ийнх 1.0 пунктээр тус тус буурсан байна.

Монгол Улсын Засгийн газар 2020 оны 12-р сарын 13-нд “Корона вирус (Covid 19) цар тахлын үед айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоол гаргаж ААН-ийн үйл ажиллагаанд томоохон дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэрт судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 1595 (66.8%) нь хамрагдаж, 793 (33.2%) нь хамрагдаагүй байна. Эндээс ААН-үүд уг дэмжлэгт хамрагдаж байгаа нь харагдаж байна.

Корона вирусний (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээтэй холбоотойгоор үйл ажиллагаа нь хүндэрч байгаа хэдий ч судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн зөвхөн 244 (10.2%) нь ажиллагчдаа цомхотгох арга хэмжээ авсан байна. Эндээс ААН-үүд аль болохоор ажиллагчдаа цомхотгохоос зайлсхийж, ажлын байрыг хадгалах эрмэлзэлтэй байгаа нь харагдаж байна.

ААН-үүд төрөөс зээлийн хүүг тэглэх, бага хүүтэй, хөнгөлөлттэй зээл олгох, НӨАТ, НДШ, ААНОАТ-ыг тэглэх, татварын хөнгөлөлт үзүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, мөн нийслэл Улаанбаатар хотод хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор QR кодыг ААНБ-үүдэд чөлөөтэй олгох, түгээлтийн асуудлыг шийдвэрлэх, хөл хорионы үеэр оновчтой, зөв төлөвлөлт хийж, халдварын голомтыг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг хүссэн байна.

Цаашид “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацааг үргэлжлүүлбэл ААН-ийн үйл ажиллагаанд маш их сөрөг нөлөө үзүүлнэ гэж судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх нь буюу 1346 (56.4%) нь хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 33.1 хувь үйл ажиллагаагаа хэзээ хэвийн явагдаж эхлэхийг тодорхой мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна. Энэ нь эхний шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад 1.7 пунктээр, 2 дахь шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад 4.1 пунктээр буурсан байна.